

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



“АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ” ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

“ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ”-нд ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439,

Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225

Ахлах аудитор Д.Ихбаяр
Аудитор Д.Должинсүрэн
Утас: 7059-3113,
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг 1. “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн аудитаар өгсөн зарим албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, үр дүн мүүтэй байна.</u>	6-10
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Аудитаар нийт 11 заалт зөвлөмж өгснөөс 5 зөвлөмж хэрэгжиж, хэрэгжилт 45.5 хувьтай байна.	6-9
Ахлах аудитор Д.Ихбаяр	1.2 Аймгийн ЗДТГ-т өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.	9-10
Аудитор Д.Должинсүрэн	1.3 УАГ-аар дамжуулан ЭМЯ-нд хүргүүлсэн 3 саналаас эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа программ хангамжийн уялдаа холбоо, сайжруулалттай холбоотой санал нь зөвлөмжийн хэсэгт тусгагдсан байна.	10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593113 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Дүгнэлт	11
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот 2023 оны 6 дугаар сар		



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 17/18

Мянголговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлтийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шалгуулах эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9, 19 дүгээр зүйлийн 19.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Төрөөс эмийн талгаар баримтлах болонгийн хэрэгжилт, үр нөлөө” (ДУА-2021/14-11-ШТА-ГА)-нд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар нэрлэсэн зөрчлийн загварыг (албан шаардлага) ний хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Төрөөс эмийн талгаар баримтлах болонгийн хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн аудитын тайланг Дундговь аймгийн Засаг дарга, Аймгийн Эрүүд мэндийн газрын даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийн бүрэн хангуулан, үр нөлөөгийн талаар 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Төрийн аудитын газарт даруу яруулахийг Дундговь аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбаяр/, Аймгийн Эрүүд мэндийн газрын дарга /Б.Алтантөгс/ нарт зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор /Д.Ихбаяр/, аудитор /Д.Должинсүрэн/ нарт үүрэг болгосугай.

Р.МӨНХТОГТОХ

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЭЭС	Эм эргэлтийн сан
ЭМЧМУАЭ	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
ЭЭЗХ	Эмийн эмчилгээг зохицуулах хороо
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хяналт шалгалт хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.3, МУЕА-ын 2022 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”, Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу өөрийн санаачилгаар хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах” зорилтын хүрээнд **“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”**-нд хийсэн аудитын үр дүнд өгсөн албан шаардлага, зөвлөмж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн саналын хэрэгжилтийг ирүүлсэн хариу тайлбар, нотлох баримттай газар дээр нь тулган шалгах, үр дүнг тооцож зорилтын биелэлтийг хангах, аудитын үр дүнг тайлагнахад чиглэнэ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Хяналт шалгалтад илрүүлэлтийн хүснэгтэд тусгасан асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах стандарт, хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ❖ АДБОУС
- ❖ Төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020
- ❖ МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам
- ❖ МУЕА-ын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан ГА-ын заавар, аргачлал /5.8/

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Дундговь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумдын Эрүүл мэндийн төв, Эмийн эргэлтийн сангууд, хувийн эмийн сан болон бусад холбогдох байгууллагын аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулсан.

Шалгалтыг аудитын матрицад тусгасан асуулт, арга зүй, нотлох баримт цуглуулах аргуудын хүрээнд хийж, нөхцөл байдал, үр дүнг аудитын илрүүлэлтийн хүснэгтээр баримтжуулсан.

Аудитын арга зүй:

Шалгалтыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2021

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитын дүн

он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, шалгалтын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар 2023 оны 06 дугаар сарын 05-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

Аудитаар байгууллагын удирдлага болон аудит хийсэн багт гүйцэтгэлийн аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, аудитын мөрөөр хяналт тавих үе шатанд илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.



БҮЛЭГ 1. Аудитаар өгөгдсөн зарим албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй, үр дүн муутай байна.

1.1 АУДИТААР ӨГӨГДСӨН 11 ЗААЛТ ЗӨВЛӨМЖ ӨГСНӨӨС 5 ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИЖ, ХЭРЭГЖИЛТ 45.5 ХУВЬТАЙ БАЙНА.

1.1.1 Аймгийн ИТХ, Засаг дарга Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх “Дундговь аймгийн дэд хөтөлбөр”-ийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтийг хангаж ажиглаагүй байна.



Аудитын үр дүнд Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх “Дундговь аймгийн дэд хөтөлбөр”-ийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-д танилцуулан дүгнэлт өгч бодлогын хэрэгжилтийг хангах асуудлаар аймгийн ИТХ, ЗДТГ, ЭМГ-т зөвлөмж өгсөн байна.

“Төрөөс Эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг нь хүчингүй болсон шалтгаанаар дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй байна.

2023 оны байдлаар “Дундговь аймгийн дэд хөтөлбөр” болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө нь хүчинтэй, тус хөтөлбөрийг аймгийн урт болон дунд хугацааны баримт бичигтэй нийцүүлэн шинэчлээгүй байна. Энэ нь дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, ажилтнуудын ажлын хариуцлага, ур чадвар, хандлага, ажлын уялдаа холбоо муу байгаатай холбоотой байна.

Иймээс эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажлын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Мөн Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх “Дундговь аймгийн дэд хөтөлбөр”-ийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд тусгагдсан бодлогын баримт бичигтэй нийцүүлэн шинэчлэх асуудлаар санал боловсруулан шийдвэрлүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.1.2 Сумдын ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг судалж орон нутгийн хувьд хамгийн оновчтой бүтэц, зохион байгуулалтын гарц, шийдлийг олж, шийдвэрлүүлээгүй байна.



Аймгийн ИТХ, ЗДТГ-аас сумдын ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг судалж орон нутгийн хувьд хамгийн оновчтой бүтэц, зохион байгуулалтын гарц, шийдлийг олж, шийдвэрлэх асуудлаар дараах ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн ЭМГ-аас 2023 онд ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар сүүлийн 3 жилийн статистик үзүүлэлтийн түвшинд судалгаа шинжилгээ хийж “ЭЭС-ийн зөвлөлийн үйл ажиллагаа, хяналт муу, мэргэжлийн боловсон хүчний дутагдал, эмийн сангийн эрхлэгчийн идэвх санаачилга, санхүүгийн хяналт хангалтгүй, сумын хүн ам, алслагдсан байдал зэргээс шалтгаалж ихэнх ЭЭС-ийн үйл ажиллагаа нь доголдолтой, санхүүгийн тайлангийн харьцаа алдагдсан, алдагдалтай ажиглаж байна” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Гэвч судалгааны үр дүнд, дүн шинжилгээ хийх, ЭЭС-уудын бүтцийг оновчтой шийдсэн аймгуудын туршлагыг судалж аймагт нэвтрүүлж болох оновчтой сонголтын санал боловсруулах,

шийдвэр гаргах түвшний болон мэргэжлийн байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлж, ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх асуудлаар орон нутгийн хувьд оновчтой гарц, шийдлийг гаргах ажил нь хийгдээгүй байна.

Иймд ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд судалгаа хийгээд орхих биш, гол нь орон нутгийн хувьд хамгийн оновчтой бүтэц, зохион байгуулалтын гарц, шийдлийг олж, шийдвэрлүүлснээр зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдах тул тус ажлыг яаравчлах шаардлагатай байна.

1.1.3 Аймгийн эм зүйн салбарын хэмжээнд дутагдалтай байгаа орон тоог 14 эм зүйч, эм найруулагчаар нөхөн бүрдүүлсэн байна.



Аудитаар аймгийн хэмжээнд эм зүйч, эм найруулагчийн 44 орон тоо дутагдалтай байгаа талаар судалгааг гарган дутагдалтай орон тоог нөхөн бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн удирдлага, их дээд сургууль болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн. Уг ажлын хүрээнд эхний ээлжид сумдын ЭЭС-ийн эм найруулагчийн орон тоог нөхөхөөр 2022 онд "Энэрэл" анагаах ухааны дээд сургуульд эм найруулагчаар 10 суралцагч бүртгүүлсэн байна. Мөн ЭЗШУИС-ийн эм зүйн удирдлага менежментийн ангид 4 эм зүйч суралцаж төгссөн байна.

Гэвч одоогийн байдлаар Цагаандэлгэр, Дэрэн, Хулд сумдад мэргэжилтэн байхгүй эмийн сангууд ажиллахгүй байна. Энэ нь сумдын хүн амын тоо, борлуулалтын орлогоос хамааран цалин бага байдаг, мөн төрийн албанд ажилласан жилд тооцдоггүй тул төрөөс олгодог тэтгэмж, урамшуулалд хамрагдаж чаддаггүй зэрэг шалтгаанаар мэргэжлийн эм зүйч нар сумдын ЭЭС-д ажиллахгүй байна.

Энэ нь сумдын хүн амыг зайлшгүй шаардлагатай, чанартай, аюулгүй эмээр хангах үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэхэд хүндрэл учирч, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө учирч болзошгүй нөхцөл байдлыг бий болгож байна.

1.1.4 ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комисс нь эмийн сангийн тусгай зөвшөөрлийн сунгалтыг хууль, журмын хүрээнд шийдвэрлээгүй байна.



Тайлант хугацаанд ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комисс 5 удаа хуралдаж, эмнэлэг, ЭМТ, ЭЭС, эмийн сан, ариутгал халдваргүйтгэл, лаборатори зэрэг нийт 17 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж, шинээр 2 эмийн санд тусгай зөвшөөрөл олгосон байна.

2018 оноос хойш, ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгоход 2018-2020 онд баримтлах тэргүүлэх чиглэл шинэчлэгдээгүй учир шинээр 2 эмийн санд зөвшөөрөл олгохдоо тус журмын 2.3.1-дахь /Эмийн сангийн үйлчилгээ дутагдалтай газар нутгийн хүн амд эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа./ заалтыг баримтлан олгосон байна.

Монос болон Онч эмийн сангуудын 1-р зэрэглэлийн стандартын шаардлагыг хангаагүй байхад тусгай зөвшөөрлийг 2023 онд сунгасан байна. Энэ нь комисс эмийн сангийн тусгай зөвшөөрлийн сунгалтыг хийхдээ стандартын шаардлага хангуулалгүй, зөвхөн хүсэлтийг үндэслэн сунгалтыг хийж байгаатай холбоотой байна.



1.1.5 Аймгийн төвийн нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эрхлэгч нар эм зүйн албаны менежментээр бүрэн мэргэшсэн байна.

Тайлант хугацаанд аймгийн төвийн Монос, Эдмонс, Буяндэлгэр, Тавин ус зэрэг нийт 4 хувийн эмийн сангийн эм зүйч нар эм зүйн албаны менежментээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж аймгийн төвийн бүх эм зүйч нар мэргэшсэн байна.

Харин сумын ЭЭС-ийн эм найруулагч нар ажлын нөхцөл боломжоос шалтгаалан суралцах боломжгүй байна. Тухайлбал: Эм зүйн албаны менежментээр мэргэшүүлэх сургалт нь Улаанбаатар хотод танхимаар 6 сарын хугацаанд суралцах шаардлагатай байдаг тул энэ хугацаанд сумын ЭЭС- ууд ажиллах боломжгүй болж байна.



1.1.6. Эрүүл мэндийн төвүүд эмийн гаж нөлөө эмийн хэрэглээтэй холбоотой үүссэн аюулгүй байдлын мэдээллийн асуудал хариуцсан “мэргэжилтэн”-тэй болж, “орон нутгийн иргэд” эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллээр хангагдах нөхцөл боломж бүрдсэн байна.

Аймгийн ЭМГ-аас эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллийг эм, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдийн дунд тогтмол зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийн хүрээнд 2022-2023 онд эм зүйн сургалтыг 6 удаа цахимаар, 6 удаагийн танхимын сургалтад нийт 421 хүнийг хамруулсан байна.

2022-2023 онд Аймгийн ЭМГ-аас эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх 12 удаагийн сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж нийт 1412 эм, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдийг хамруулсан байна. Мөн байгууллагын facebook хуудсаар эмийн гаж нөлөө, эмийн хэрэглээтэй холбоотой асуудлаар танилцуулга видео, шторк хэлбэрээр танилцуулгыг байнга хийж байна. Нэгдсэн эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийн хувьд хэвтэн эмчлүүлэгч нарын дунд 6-8 удаагийн сургалт зохин байгуулж 1409 иргэнийг хамруулсан байна.

ЭМС-ын 2023 оны А/67 дугаар тушаалаар “Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журам” шинэчлэгдэж иргэн, эмнэлгийн мэргэжилтэн www.mmra.gov.mn цахим хуудаст байршуулсан гаж нөлөө мэдээлэх цэсээр нэвтрэн мэдээлэл өгөх боломж бүрдэж мөн 2 эмнэлэг, 15 эрүүл мэндийн төв, 2 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эмийн гаж нөлөө эм хэрэглээтэй холбоотой үүссэн аюулгүй байдлын мэдээллийн асуудал хариуцсан ажилтныг томилон ажиллуулж байна. Дундговь аймагт 2021-2023 онд 4 иргэнд тохиолдсон эмийн гаж нөлөө бүртгэгдсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас сумдын ЭМТ-үүд болон нэгдсэн эмнэлгийн ЭЭЗХ-ны эмнэлгийн тусламж үйлчилгээнд эм зүйн эрх зүйн баримтын мөрдөлтийн байдалд хяналт хийж үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж 18 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллаж байна.

1.1.7 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдэх хөнгөлөлттэй эмийн цахим жорын бичилт хангалтгүй байсан байна.



2023 онд УАГ-ын нэгдсэн удирдамжаар “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар Нэгдсэн эмнэлгийн эмч нарын хөнгөлөлттэй эмийн цахим жорын бичилтийг шалгаж 2021 онд хийсэн “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн

хөнгөлөлттэй эмийн жорыг цахимаар тогтмол бичиж байх зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн тул зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ, ЗДТГ /Нийгмийн бодлогын хэлтэс/ зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөө гаргаагүй, биелэлтийг нь тооцоогүй, хариу тайлбарыг хугацаа хоцроож ирүүлсэн байна.

Аймгийн ЭМГ болон Нэгдсэн эмнэлэг аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн хариуг хугацаанд ирүүлсэн. Харин аймгийн ИТХ, ЗДТГ /Нийгмийн бодлогын хэлтэс/ зөвлөмжийн хариу тайлбарыг хугацаа хоцроож ирүүлсэн байна. Дээрх байгууллагуудад зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж үр дүнг, тооцож биелэлтийг хангуулсан нотлох баримт байхгүй байсан. Тухайлбал: Аймгийн ИТХ –ын ажлын албанд зөвлөмжийн хариу ирүүлэх талаар мэдэгдэхэд, тус аудитын тайлан, зөвлөмжийн хариу хүргүүлэх талаар мэдээлэлгүй байсан.

1.2 АЙМГИЙН ЗДТГ-Т ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.2.1 Аймаг эм био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч байхгүй байна.



Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/400 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс ажиллах” журам болон аудитаас өгсөн албан шаардлагын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын 16 өдрийн А/229 дугаар тушаалаар комиссыг шинэчлэн баталж, тус комиссын бүрэлдэхүүнд хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны төлөөллийг саналын эрхгүй оруулан баталсан байна. Харин аймгийн Засаг даргын 2022 оны 07 сарын 01 өдрийн А/295 дугаар тушаалаар комиссыг шинэчлэн батлахдаа комиссын даргаар Эрүүл мэндийн газрын даргыг баталж, хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оруулаагүй байна. Энэ нь журмын 1.5-дахь /Комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бодлого, хэрэгжилт, зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх комисс 9-11, эм, эмнэлгийн хяналт зохицуулалтын газрын дэргэдэх комисс 9-11, Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх комисс 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна./ заалтыг зөрчсөн байна.

Монгол Улсын хэмжээнд Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж, эм био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч чөлөөлөгдөн, Эм, эмийн хэрэгслийн газрын харьяа хяналтын улсын байцаагчийн орон тоонд мэргэжлийн хүн томилогдоогүй учир 2023 оноос аймгийн эмийн сангуудад мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой хяналт шалгалт хийгдээгүй байна. Энэ нь журмын 1.5-дахь /Тусгай зөвшөөрлийн бодлого хэрэгжилт, зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон төрийн бус байгууллагатай хамтран явцын хяналтыг хийж, Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөл, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцох/ заалтыг хэрэгжих боломжгүй болох нөхцөлийг бий болгосон байна.

Иймд эм био бэлдмэлийн хяналтын улсын байцаагчтай болох асуудалд мэргэжлийн байгууллага болон аймгийн удирдлагууд анхаарал хандуулж, орон тоог нөхөх шаардлагатай байна.

1.2.3 Аймгийн төвийн А бүсчлэлийн газарт үйл ажиллагаа явуулж байгаа хоёрдугаар зэрэглэлийн 2 эмийн санг /”Буяндэлгэр”, “Өсгө жирэм”/ стандартын шаардлага хангуулах албан шаардлага хэрэгжээгүй байна.



2021-2023 онд ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнд 2 удаа өөрчлөлт орсон боловч аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн аудитаар өгөгдсөн Аймгийн төвийн А бүсчлэлийн газарт үйл ажиллагаа явуулж байгаа хоёрдугаар зэрэглэлийн 3 эмийн сангийн /”Буяндэлгэр”, “Өсгө жирэм”, “Мишээл”/ тусгай зөвшөөрлийг стандартын шаардлагын дагуу болгох асуудлыг танилцуулан шийдвэрлүүлээгүй байна. Харин “Мишээл” эмийн сан байршлаа сольж, А бүсчлэлээс гарсан байна.

Аймгийн А бүсчлэлийн газарт үйл ажиллагаа явуулж байгаа хоёрдугаар зэрэглэлийн эмийн сангуудаас /”Буяндэлгэр”, “Өсгө жирэм”/ эмийн сангийн стандартын шаардлагыг хангуулаагүй байна.

1.2.4 Эмийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зөрчилд өгөгдсөн албан шаардлага хэрэгжсэн байна.



Албан шаардлагаар “Онч”, “Мишээл” эмийн сангуудад мэргэжлээрээ 3 жил ажиллаагүй эм зүйч эмийн сангийн эрхлэгчээр ажилладаг, “Өсгө жирэм”, “Монос Дундговь”, “Ар Үр”, “Онч” эмийн сангууд нь эмийн сангийн барилга, байгууламжид тавих шаардлага хангаагүй, ажилчдын амралтын өрөө болон эмийн нөөцийн өрөөгүй, “Өсгө жирэм” эмийн сан нь ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй зөрчлүүдийг газар дээр нь очиж шалгахад ЭМГ-аас 2022 оны 05 сард дээрх зөрчлүүдтэй холбоотой давтан хяналт хийж, мэдэгдэл хүргүүлэн, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Аймгийн ЭМГ аудитаар өгөгдсөн албан шаардлагын биелэлтийн хариуг хугацаанд ирүүлсэн. Харин аймгийн ЗДТГ /Нийгмийн бодлогын хэлтэс/ албан шаардлагын хариу тайлбарыг хугацаа хоцроож ирүүлсэн байна.

1.3 ҮАГ-ААР ДАМЖУУЛАН ЭМЯ-НД ХҮРГҮҮЛСЭН 3 САНАЛААС ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ АШИГЛАГДАЖ БАЙГАА ПРОГРАММ ХАНГАМЖИЙН УЯЛДАА ХОЛБОО САЙЖРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ НЬ ЗӨВЛӨМЖИЙН ХЭСЭГТ ТУСГАГДСАН БАЙНА.

1.3.1 ҮАГ-аар дамжуулан ЭМЯ-нд хүргүүлсэн ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт, аймгийн эрүүл мэндийн газрын эмийн чанар аюулгүй байдал эмийн зохистой хэрэглээ, эмийн хэрэгслийн хангамж тусгай зөвшөөрөл хариуцсан орон тоог нэмэгдүүлэх саналтай холбоотой зөрчлийн илрүүлэлтүүд нэгтгэсэн тайланд тусгагдсан боловч ЭМС, ЭМДҮЗ-ийн даргад хүргүүлсэн зөвлөмжид дурдагдаагүй байна.

Харин Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа программ хангамжуудын уялдаа холбоог сайжруулж, хоорондоо мэдээллээ солилцох боломжийг бий болгон, ажлын ачааллыг бууруулахтай холбоотой санал нь зөвлөмжид тусгагдсан боловч тодорхой ажил хийгдээгүй байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг 1. “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн аудитаар өгсөн зарим албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй, үр дүн муутай байна.

1.1. Аудитаар 11 заалт зөвлөмж өгсөнөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 5 зөвлөмж хэрэгжиж, хэрэгжилт 45.5 хувьтай байна.

Эм зүйн салбарын хэмжээнд дутагдалтай орон тоог нөхөх, эмийн сангийн эрхлэгч нарыг эм зүйн албаны менежментээр мэргэшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүний үр дагавар ач холбогдлыг сурталчлах, ЭМГ-аас ЭМТ-үүд болон ЭЭЗХ-г арга зүй удирдлагаар хангаж ажиллах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж тодорхой үр дүнд хүрч ахиц гарсан байна. Тухайлбал: Эрүүл мэндийн төвүүд эмийн гаж нөлөө эмийн хэрэглээтэй холбоотой үүссэн аюулгүй байдлын мэдээллийн асуудал хариуцсан “мэргэжилтэн”-тэй болж, аймгийн төвийн нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эрхлэгч нар эм зүйн албаны менежментээр бүрэн мэргэшсэн, аймгийн эм зүйн салбарын хэмжээнд дутагдалтай байгаа орон тоог тодорхой хэмжээнд нэмэгдүүлэхээр эм найруулагчаар 10 хүнийг сургаж эхэлсэн байна.

Харин ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг судалж орон нутгийн хувьд хамгийн оновчтой бүтэц, зохион байгуулалтын гарц, шийдлийг олж, шийдвэрлүүлэх зөвлөмжийн хувьд хэрэгжих шатандаа, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх “Дундговь аймгийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт үр, дүнг тооцож хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд тусгагдсан бодлогын баримт бичигтэй нийцүүлэн шинэчлэх зөвлөмжийг огт хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, ажилтнуудын ажлын хариуцлага, ур чадвар, хандлага, ажлын уялдаа холбоо муу байгаатай холбоотой байна.

1.2. Аймгийн ЗДТГ-т өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлагын 50 хувь буюу 1 албан шаардлагаар өгөгдсөн 2 асуудал хэрэгжээгүй байна. Аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа асуудлуудын хувьд тодорхой хэмжээнд ахиц гарсан байна. Жишээ нь эмийн сангийн шалгалтаар илэрсэн ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлдэг болсон, зөрчлүүдийг арилгасан. Эмийн сангийн эрхлэгчээр мэргэжлээрээ 3 жил ажилласан эм зүйчийг ажиллуулдаг болсон. Зарим эмийн сангийн барилга, байгууламжид тавих шаардлагын дагуу ажилчдын амралтын өрөө болон эмийн нөөцийн өрөөтэй болгосон.

1.3. ҮАГ-аар дамжуулан ЭМЯ-нд хүргүүлсэн 3 саналаас эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа программ хангамжийн уялдаа холбоо сайжруулалттай холбоотой санал нь “Нэгдсэн тайлан”-ийн зөвлөмжийн хэсэгт тусгагдсан байна.

Монгол Улс, Дундговь аймаг 48890, Сайнцагаан сум, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn **ОН**